

4

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ НЬ

Ц. Даваадорж, А. Дэмбэрэл

1. Судлах шаардлага

Үндэсний тооцооны систем (ҮТС) бол эдийн засгийг бүхэлд нь өөр хоорондоо харилцан уялдаатай загвар хэлбэрээр үзэж, түүний аль нэг хэсэгт гарах өөрчлөлтүүд, макро эдийн засгийн бусад гол үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлөхийг тооцох, шинжилгээ хийх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах бололцоо олгодгоороо төрийн зүгээс эдийн засгийг зохицуулахад шаардагдах удирдлагын мэдээллийн гол бүрэлдэхүүн хэсэг нь болж байдаг. Далд эдийн засгийн хэмжээг тооцож дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-нд тусгах нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан манай орны хувьд урьд өмнө судалж байгаагүй, зайлшгүй судалж шийдвэрлэх шаардлагатай шинэ чиглэл юм. Энэхүү судалгаанд дэлхийн нийтийн ололт амжилтыг ашиглах нь мэдээж. Үүний хамт өөрийн орны онцлогийг тусгасан онол, арга зүйг боловсруулах учиртай. Одоогоор манайд энэ чиглэлийн ажил далд эдийн засгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох албан бус секторын талаарх 2 удаагийн судалгаа хийсэн төдийгөөр хязгаарлагдаж байна.

Аль ч орны далд эдийн засгийн үйл ажиллагааг тусгасан мэдээлэл ховор, тооцох нэгдсэн найдвартай арга байдаггүй нь түүний хэмжээг тодорхойлоход ихээхэн бэрхшээл учруулдаг. Албан бус секторын судалгааны мэдээллийн эх үүсвэр, хамрах хүрээ, арга зүйн зарим асуудлын хувьд ч бас төгс төгөлдөр шийдвэрлэгдээгүй зүйл бий. Иймээс аль боломжтой мэдээллийн эх үүсвэрийг ашиглах, янз бүрийн тооцоо, судалгаа хийх хэд хэдэн аргыг хослуулан жишиж үзээд оновчтойг нь сонгох зэргээр далд эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг тооцож ДНБ-нд оруулах шаардлага гарч байна.

Далд эдийн засгийн хэмжээг тооцож ДНБ-д оруулах ажлыг зах зээлийн эдийн засгийн онол, НҮБ болон олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудаас боловсруулан гаргасан арга зүйн баримт бичгүүд, зах зээл хөгжсөн болон манайтай адил төвлөрсөн төлөвлөгөөт

эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй бусад улсуудын энэ талаархи ажлын туршлага, сүүлийн жилүүдэд ДНБ-ийг тооцох талаар манай улсад гаргасан баримт бичиг, аргачлал, практик тооцоо, энэ чиглэлээр боловсруулсан зөвлөмж, холбогдолтой бусад ном, хэвлэлийн материалыг ашиглан хийх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

2. Далд эдийн засгийн тухай


Далд эдийн засаг гэж нэрлэж заншсан ойлголтыг сүүлийн үед дэлхий дахинд илүү өргөн хүрээгээр, албан ёсны статистикт хамрагдаагүй, үүний улмаас ДНБ-ний тооцоонд ороогүй эдийн засгийн хэмжээг ойлгож, гол төлөв **ажиглалтад өртөөгүй эдийн засаг** (англиар "non observed economy", оросоор "ненаблюдаемая экономика") гэсэн утгаар хэрэглэдэг болсон. Манай улсад ч мөн энэ ойлголтоор авч хэрэглэж байна.

ДНБ-ний тооцоонд ороогүй эдийн засаг нь дараахь 3 үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болдог гэж үздэг /зураг 1/. Үүнд:

1. Далд буюу сүүдрийн үйл ажиллагаа-нд хуулиар хориглоогүй үйл ажиллагааны татвараас нуусан хэм хэмжээг нь дарагдуулсан орлогыг хамруулдаг.
2. Албан бус секторын үйл ажиллагаа-нд хуулийн дагуу хувь хүмүүс, өрх айлын зүгээс эрхлэн явуулсан үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэгдээгүй хэмжээг хамруулан үздэг.
3. Хууль бус үйл ажиллагаа-нд хуулиар хориглосон үйл ажиллагаа ордог. Энэ дотроо 2 янз байдаг.

Далд эдийн засгийн ангилал

Зураг 1



1. Далд буюу сүүдрийн үйл ажиллагаа: гэдэгт албан ёсны статистикт дараахь шалтгаанаар бүртгэгдээгүй бүх хууль ёсны дагуу үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулдаг. Үүнд:

- Орлогын, нэмэгдэл өртгийн бусад төрлийн татвараас зайлсхийх
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх
- Хуулийн зарим нэг заалт, хэв журмыг мөрдөхөөс зайлсхийх (цалин хөлсний доод хэмжээ, үйлдвэр техникийн аюулгүй байдлын болон эрүүл ахуйн зохих шаардлагыг хангаагүй байх гэх мэт)
- Засаг захиргааны тогтсон журмаас зайлсхийх (статистикийн асуулгын маягт болон бусад засаг захиргааны бүртгэлээс зайлсхийх)

2. Албан бус секторын үйл ажиллагаа: Хувь хүн болон жижиг үйлдвэрийн газрууд хамтын хэлбэрээр зарим нэг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэн, үйл ажиллагаанаас олох орлого нь тэдгээр бүлэг хүмүүсийн амьжиргааны эх үүсвэр болдог тохиолдол хөгжиж байгаа орнуудад түгээмэл байдаг бөгөөд энэ нь тухайн орны эдийн засагт зохих байр суурь эзэлдэг. Тэдгээр хүмүүс нь гар дээрээс наймаа худалдаа эрхлэн, тамхи, бохь, чихэр, нарийн боов, зарим тохиолдолд өөрсдийн хийсэн тавилга зэргийг худалдаалдаг байна. Ихэнх тохиолдолд тэдгээр нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байдаг бөгөөд худалдаалж байгаа бараа бүтээгдэхүүн нь ихэвчлэн өрх гэрт үйлдвэрлэсэн зүйл байх нь элбэг. Хэрвээ жижиг үйлдвэрийн газар байвал маш энгийн техник, тоног төхөөрөмж хэрэглэдэг бөгөөд багахан хэмжээний хөрөнгөтэй байдаг. Энэхүү секторт ажиллаж байгаа хүмүүсийн олох орлогын хэмжээ харьцангуй бага юм.

Эдгээр хүмүүсийн үйл ажиллагааг бүхэлд нь албан бус секторын үйл ажиллагаа гэж үздэг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан тодорхойлолт ёсоор албан бус сектор нь дараахь шинж чанартай. Үүнд:

- Багахан хэмжээний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэдэг
- Хувиараа эрхлэх аж ахуй
- Дотоод нөөц болон материалаа ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг
- Ажиллах хүчнийг түлхүү ашигладаг
- Албан ёсны сургалтаас гадуурхи хэлбэрээр ажлын туршлага хуримтлуулсан байдаг
- Тухайн үйл ажиллагааг эрхлэх, салбарт орох, гарахад амархан
- Үйл ажиллагаа эрхэлж байгаа салбар нь чөлөөт өрсөлдөөнт зах зээлтэй байдаг ба хатуу зохицуулалтгүй байдаг.
- Тухайн аж ахуйн нэгжийн эзэмшигч нь үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л үүрэг, хариуцлагыг бүрэн хариуцдаг.

Албан бус секторт хамрагдах аж ахуйн нэгжүүд бүгд татвар болон нийгмийн даатгалын шимтгэлээс зайлсхийдэггүй бөгөөд албан бус секторын үйл ажиллагааны төрөл нь маш амархан өөрчлөгддөг байна. Тухайн орны онцлогоос хамааран албан бус сектор нь нэг бол үйлдвэрлэлийн хэмжээгээр, эсвэл, засаг захиргааны бүртгэл шаардагддаг эсэхээрээ ялгаатай тодорхойлогддог. Өрхийн аж ахуйн секторын албан бус сектор нь албан бус ажиллагсадтай болон албан бус хувиараа эрхлэх аж ахуй (энэ хоёрын ялгаа нь тухайн хуулийн этгээд нь ядаж нэг ажилчныг тогтмол хөлслөн ажиллуулдаг эсвэл хөлсний ажилчид нь тохиолдлын шинж чанартай буюу хөлсгүй өрхийн гишүүд ажилладаг оршино) гэж ялгагддаг байна.

3. Хууль бус үйл ажиллагаа: Хуулиар зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа (хуулиар зөвшөөрөөгүй эм, эмийн бэлдмэлийг худалдах болон үйлдвэрлэх гэх мэт), тухайн үйл ажиллагаа, үйлдвэрлэл нь хуулиар зөвшөөрөгдсөн боловч хууль бусаар эрхэлж байгаа (тухайн эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй мөртлөө эмч хийх гэх мэт) үйл ажиллагааг хамруулна.

ҮТС-д хууль бус үйл ажиллагааг 2 үндсэн ангилалд хуваасан байдаг. Үүнд:

- Хуулиар зөвшөөрөгдөөгүй бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, тэдгээрийг худалдах, хадгалах
- Тухайн үйл ажиллагаа нь хуулиар зөвшөөрөгдсөн боловч хууль бусаар эрхэлж байгаа буюу зөвшөөрөлгүй эрхэлж байгаа

Дээр дурдсан 2 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь хоёул ҮТС-ийн үйлдвэрлэлд хамаарагдах бөгөөд зах зээлийн эрэлтэнд нийцсэн эцсийн бараа, үйлчилгээ байх ёстой. Хууль бус үйл ажиллагаанд худалдан авагч, худалдагч нар харилцан тохиролцооноос үүдэн хийгдсэн наймаа худалдааг (тухайлбал эм тариа, хар тамхи, хулгайлагдсан барааг зарах, авах, биеэ үнэлэх гэх мэт) хамруулна. Харин хоёр талын харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдээгүй (дээрэм, хулгай гэх мэт) үйл ажиллагааг хамруулахгүй. Мөн түүнчлэн хууль бус үйл ажиллагаа нь нэг бол үйлдвэрлэл эсвэл дахин хуваарилалт байж болох бөгөөд зөвхөн эхнийх нь ҮНБ-ний хэмжээнд нөлөөлнө.

Олон улсын статистикт далд эдийн засгийг 1930-аад оноос судалж эхэлсэн боловч, 1970-аад оныг хүртэл хангалттай анхаарал тавьж, ач холбогдол өгөөгүй гэж үздэг. 1970-аад онд АНУ-ын далд эдийн засаг ДНБ-д 4.2% эзэлж, Өмнөд Европт үүнээс арай илүү, харин Баруун болон Хойд Европт, Канад, Японд доогуур байсан байна.

Шилжилтийн эдийн засагтай зарим орны ДНБ-д далд эдийн засгийн эзлэх хувь

Хүснэгт 1

Улсууд	Судалгааны он	ДНБ-д эзлэх хувь
ОХУ	1998	25.0
Украйн	1998	18-19
Белорусь	1996-1997	25-35
казакстан	1998	26.8
Армен	1997	26.5-28.9

Эх үүсвэр: Европын Холбооны Статистикийн газраас Далд эдийн засгийн асуудлаар 1999 оны 7 сард Молдовт зохион байгуулсан олон улсын семинарын материал

3. Монгол улсын далд эдийн засгийн хэмжээ

НҮБ-аас анх 1968 онд боловсруулж 1993 онд дахин шинэчилсэн Үндэсний тооцооны системийн аргачлалаар далд эдийн засгийг ДНБ-д оруулж тооцохыг зөвлөмж болгосон.

Манай орны хувьд далд эдийн засгийн хэмжээг бүрэн судалж албан ёсоор тогтоогоогүй. Харин 1997 онд Дэлхийн банкнаас Улаанбаатар хотын хэмжээнд албан бус сектор дахь хэмжээг судалсан байна.¹ 1999 онд Үндэсний Статистикийн Газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх "Эдийн засгийн бодлогыг дэмжих" төсөлтэй хамтран албан бус секторын судалгааг 6 аймаг, Улаанбаатар хотод бизнесийн 14 салбарт хийж, хэмжээг нь 117 тэрбум төгрөг гэж тогтоосон нь ДНБ-ний 13.3% болсон. Энэ бол далд эдийн засгийн зөвхөн нэг томоохон хэсэг гэдэг нь ойлгомжтой. Үүний 62% нь жижиглэн худалдааны, 23.3% тээврийн үйлчилгээний салбарынх байв. Эдгээр салбарт албан бус сектор давамгайлж байлаа.²

¹ Дэлхийн банк, Хөгжлийн судалгааны төв, Жеймс Андерсон Шилжилтийн үеийн Монголын албан бус секторын хэмжээ, гарал үүсэл онцлог 1998 оны 5 дугаар сар.

² Economic Policy Support project under USAID Bill Bikales, Ch.Khurelbaatar, Karin Schelzig The Mongolian informal sector survey results and analysis April, 2000.

Далд эдийн засгийн хэмжээг тодорхойлоход төрөл бүрийн ойролцоо тооцоо хийх шаардлага их гарна.

Наад зах нь янз бүрийн үзүүлэлтийн харьцааг ашиглан мэдээллийн үнэн зөв эсэхийг магадалж болох юм. Тухайлбал, цалингийн түүвэр судалгааны материалаас хувийн өмчтэй аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчдын дундаж цалинг төрийн өмчийнхтэй харьцуулж судлах гэх мэт.

Мөн үзүүлэлтийн өөр хоорондын уялдааг ашиглан дутуу тооцож байгаа бүтээгдэхүүний хэмжээг ойролцоолон тодорхойлож болох юм. Энд юуны өмнө ДНБ-ий үйлдвэрлэл, эцсийн ашиглалтын уялдаа, нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын балансыг нэрлэж болно.

Мөн татварын албаны сүүлийн хэдэн жилийн шалгалтын материалд судалгаа хийж түүнийхээ үр дүнг ашиглан орлогын хэмжээг өсгөх, зардлыг бууруулах засварын коэффициент боловсруулж болох юм.

Далд эдийн засгийн хэмжээг тодорхойлох явцад ойролцоо тооцоо хийх шаардлага олонтаа гарна. Иймд тооцоог хар тамхи, биеэ үнэлэх, садар самууныг сурталчилах, хулгайгаар ан хийх, хууль бусаар мөрийтэй тоглоом тоглуулах, дамын наймаа (контрабанд) хийх зэргээс олж байгаа орлогыг тодорхойлох үед хэрэглэхэд тохиромжтой.

Мөн байгаль орчныг хамгаалах байгууллагуудын шалгалтын мэдээ, олон жилийн судалгаа бусад үзүүлэлтүүдийг үндэслэн хулгайн ан, зөвшөөрөлгүй ашиглаж байгаа мод, ургамал жимс, мөөг зэргээс орох орлогыг тодорхойлох боломжтой.

Иймээс аль боломжтой мэдээллийн эх үүсвэрийг ашиглах, янз бүрийн тооцоо, судалгаа хийх хэд хэдэн аргыг хослуулж жишиж үзэн оновчтойг нь сонгох зэргээр далд эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг тооцох шаардлага гарч байна.

Ашигласан материал

1. System of National Accounts 1993. Commission of the European Communities, International Monetary Fund, Organization for Economic cooperation and Development, United Nations, World Bank. Pages 121-127.
2. Statistical measurement of Non-observed economy Workshop 16-20 October, 2000 Sochi, Russian Federation.
3. Working papers of Workshop on Non-Observed Economy 5-9 July, 1999 Chisinau, Moldova.
4. Economic Policy Support project under USAID Bill Bikales, Ch.Khurelbaatar, Karin Schelzig The Mongolian informal sector survey results and analysis, April, 2000.
5. Дэлхийн банк, Хөгжлийн судалгааны төв, Жеймс Андерсон, Шилжилтийн үеийн Монголын албан бус секторын хэмжээ, гарал үүсэл онцлог, 1998 оны 5 дугаар сар.
6. Монголын эдийн засаг, шилжилтийн эдийн засгийн гарын авлага, Улаанбаатар. 1999.
7. Т.Кузнецова, Орос дахь хэвшмэл бус эдийн засгийн судалгааны зарим хандлагууд, Шинэ толь сэтгүүлийн 1999 оны №26, 126 –133 тал.